



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/74

Модот

Малчдын зөвлөгөөн-2026 арга хэмжээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2026 оны малчдын зөвлөгөөнийг 2026 оны 05 дугаар сарын 20-ний өдөр зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга	Б.Ганзориг	- Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	Б.Буяндэлгэр	- Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч
Гишүүд	У.Гантулга	- I багийн засаг дарга
	Б.Чулуунцэцэг	- II багийн засаг дарга
	Д.Мягмарсүрэн	- III багийн засаг дарга
	С.Энхнар	- IV багийн засаг дарга
	Б.Энх-Амар	- Засаг даргын Тамгын газрын мэдээлэл технологи, программ хангамж, дотоод сүлжээ хариуцсан ажилтан
	С. Баатардорж	- Соёлын төвийн даргыг түр орлон гүйцэтгэгч
	П.Ганцэцэг	- Татварын улсын байцаагч
	П.Ганчимэг	- Мал эмнэлгийн улсын байцаагч
	З.Энхбямба	- Улсын бүртгэгч
	С.Ган-Очир	- Засаг даргын тамгын газрын нярав

2. Нийт томилогдсон бүрэлдэхүүнд ажлын тусгай төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж зөвлөгөөнийг чанартай зохион байгуулахыг үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулан ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



